



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

10
АНГИ

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:



САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу балын харандаагаар будаарай.


НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР

- Сурагч М-д “Мэдээллийн технологийн сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг авахыг хүсвэл дараах холбоос дээр дарж ороорой.” гэсэн цахим шуудан иржээ. Тэрээр холбоосны аюулгүй байдлыг шалгахгүйгээр шууд нэвтрэн, мэдээллүүдтэй танилцах явцад түүний компьютер вирустэж, хувийн мэдээлэл нь алдагджээ. Энэ нь интернэт орчинд үйлдэгддэг гэмт хэргийн аль төрөлд хамаарах вэ?

A. Identity theft B. Phishing C. Cyber violence D. Man in the Middle
- Мэдээллийг хамгаалах аргуудыг ҮНЭН (Y), ХУДАЛ (X)-аар нь зөв тодорхойлсон хэсгийг сонгоно уу.
 - Өөрийн гар утасны мэдээллээ тусгай системээр хамгаалах. Жишээ нь: царай таниулах (face recognition)
 - Өөрийн банкны картын нууц үгээ өөрийн төрсөн өдрөөр хийх нь аюулгүй, эрсдэлээс сэргийлнэ.
 - Гар утасны гэр (case) нь мэдээллээ хамгаалах логик хамгаалалт юм.
 - Би өөрийн чухал мэдээллээ үүлэн технологи ашиглан хадгалдаг. Энэ нь мэдээллээ хамгаалах арга
 - Өөрийн ашигладаг мэдээлэл хадгалах төхөөрөмжүүдийг эрсдэлээс сэргийлэхийн тулд вирусийн программ суулгах нь хамгийн энгийн алхам

A. 1-Y, 2-Y, 3-Y, 4-Y, 5-Y
B. 1-X, 2-X, 3-X, 4-X, 5-Y
C. 1-Y, 2-Y, 3-Y, 4-X, 5-Y
D. 1-Y, 2-X, 3-X, 4-Y, 5-Y

- Сурагч М интернэтээс MS Office 2019 программыг татан авч суулгахад дараах мэдэгдэл бүхий цонх гарч иржээ. Энэ нь тоон оюуны өмчийн хулгайг багасгах аль аргад хамаарах вэ?



- A. Тоон гарын үсэг /Digital Signature/
B. Машин хамаарал /Machine dependence/
C. Тоон усан тэмдэг /Digital Watermark/
D. CD түлхүүр /CD key/

- ICT.docx нэртэй гарын авлагыг хэвлэж нийтэд тараах шаардлага гарав. Дараах шаардлагуудын аль нь оюуны өмчтэй холбоотой вэ?

A. Агуулгад ашигласан эшлэл, зүүлтийг зөв оруулсан.
B. Цаасны хэмжээг зөв сонгосон.
C. Сэдвийн агуулгаа зөв сонгосон.
D. Үсгийн хэмжээг баримтад тавигдах шаардлагад нийцүүлэн сонгосон

5. Сурагч Б 7-р сарын 10-ны Монгол Улсын төрийн далбааны өдөрт зориулан видео мэдээлэл бэлтгэж өөрийн фэйсбүүк хуудастаа оруулжээ.

Түүний видео мэдээлэлд орсон дараах агуулгуудаас зохиогчийн эрхээр хамгаалагдах 3 агуулгыг сонгоорой.

1. Монгол Улсын төрийн далбааны MNS 6262:2011 стандарт
2. Төрийн далбааны үүсэл, хөгжлийг тайлбарлан бичсэн номын хэсэг
3. Төрийн далбааны түүхийг харуулсан үе үеийн төрийн далбааны зургууд
4. Төрийн далбааг цэнгэлдэх хүрээлэнд мандуулж буй телевизийн нэвтрүүлэг
5. Төрийн далбааны бэлгэдлийн тухай мэдээллийн сайтад тавигдсан нийтлэл

A. 1, 2, 3 B. 1, 3, 5 C. 2, 3, 4 D. 2, 4, 5

6. Программуудыг ангилалтай нь зөв харгалзуулна уу?

- | | |
|--------------|--------------------------------------|
| 1. Audacity | a. Чөлөөт программ хангамж |
| 2. MS Access | b. Чөлөөт, нээлттэй программ хангамж |
| 3. Paint.NET | c. Хаалттай программ хангамж |

A. 1a,2b,3c B. 1a,2c,3b C. 1b,2c,3a D. 1c,2b,3a

7. Чөлөөт, нээлттэй эхийн программ хангамжийн давуу талыг зөв тодорхойлсон өгүүлбэрүүдийг сонгоно уу.

1. Дурын хөгжүүлэгч уг системийг сайжруулах боломжтой тул системийн шинэчлэлт маш богино хугацаанд хийгддэг.
2. Мэдээллийн аюулгүй байдал, техник хэрэгслийн үйл ажиллагааны бүрэн байдлыг хангана.
3. Гэрээний хугацаанд программ хангамжийн холбогдох бүх дэмжлэг, үйлчилгээг үнэ төлбөргүй авах боломжтой.
4. Программыг үнэгүй хэрэглэх боломжтой байдаг.

A. 2, 3 B. 2, 4 C. 1, 4 D. 1, 3

8. дээр үндэслэн дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргах боломжтой.

A. Боловсруулалт B. Мэдлэг C. Мэдээлэл D. Өгөгдөл

9. Багц мэдээлэл боловсруулах үе шатын **2, 5, 8** дугаарт харгалзах хариултуудыг зөв дараалалд оруулна уу.

Багц мэдээлэл боловсруулах үе шат

1. Багц мэдээлэл үүсгэх зорилго тодорхойлох
2. **Мэдээллээ эмх цэгцтэй хэлбэрт оруулан хадгалах**
3. Мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлох
4. Хэрэгцээт мэдээллийг цуглуулах
5. **Багц мэдээлэлд орох агуулгуудыг тодорхойлох**
6. Мэдээлэл бүрэн, гүйцэд, баталгаатай эсэхийг шалгах
7. Мэдээллийг боловсруулах дүрэм, аргачлалыг тодорхойлох
8. **Мэдээллийг боловсруулах технологиудыг сонгох**
9. Багц мэдээллийг нэгтгэн боловсруулах
10. Мэдээллийн боловсруулалтад дүн шинжилгээ хийх

A. 2, 5, 8
B. 5, 8, 2
C. 5, 2, 8
D. 2, 8, 5

10. Өгөгдөл болон мэдээлэлд харгалзах 2 жишээг сонгоно уу.

- | | | | |
|-----------------|--------------------------------|-----------------|-----------------|
| 1. Өгөгдөл | a. Ану 10-р анги. | | |
| 2. Мэдээлэл | b. Цас -9 | | |
| | c. 10 Ану | | |
| | d. Өнөөдөр цас орж -9°C байна. | | |
| A. 1-a,b 2- c,d | B. 1-b,c 2- a,d | C. 1-a,d 2- b,c | D. 1-a,c 2- b,d |

11. Сурагч М эрүүл мэндийн хичээл дээрээ “Эрүүл хооллолт” сэдэвт илтгэл танилцуулах болов. Дараах үе шатуудын аль хэсэгт MS PowerPoint программыг ашиглах вэ?

- A. Мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлох
- B. Тодорхойлсон дүрэм, аргачлалаар боловсруулах технологийг сонгох
- C. Цуглуулсан мэдээллийн бүрэн, гүйцэд, баталгаатай эсэхийг шалгах
- D. Мэдээллийн боловсруулалтад дүн шинжилгээ хийх

12. Багц мэдээллийн онцлог шинжийг **агуулаагүй** мэдээллийг сонгоно уу.

- A. ангийн булан
- B. 10а ангийн сурагчдын дүнгийн хүснэгтийн файл
- C. хоорондоо холбоо хамааралгүй зургуудын цуглуулга
- D. Л.Түдэвийн “Хорвоотой танилцсан түүх” зохиол

13. Мультимедиа элементүүдийг сонгоно уу.

- A. аудио, бичвэр, зураг, файл
- B. файл, аудио, зураг, видео
- C. аудио, бичвэр, зураг, хөдөлгөөнт зураг
- D. хөдөлгөөнт зураг, диск, файл, аудио

14. Аудио файлын зөв төрлүүдийг сонгоно уу.

- A. *.WAV *.ACC *.MP3 *.AIF*.MID
- B. *.MP3 *.GIF *.MOV *.PNG *.WMV
- C. *.MID *.WAV *.WMV *.AVI *.TIFF
- D. *.MID *.WAV *.MOV *.AIF *.JPEG

15. Мультимедиа элементүүдийг үүрэг, зориулалттай нь зөв харгалзуулна уу.

- | | |
|--------------|--|
| 1. Зураг | a. Үсэг, тоо, тэмдэгтээс бүрдэх ба элементүүдийг тайлбарладаг. |
| 2. Бичвэр | b. Пикселийн дөрвөлжин тортон сүлжээс |
| 3. Аудио | c. Нэг элементээс нөгөө элемент рүү шилжих эфект |
| 4. Видео | d. Хөгжим, яриа, дижитал хэлбэрт ямар ч төрлийн дууны дохио |
| 5. Хөдөлгөөн | e. Хөдөлгөөн бүхий зургийн дараалал |
-
- | | |
|-------------------|-------------------|
| A. 1b,2a,3d,4e,5c | B. 1b,2a,3c,4d,5e |
| C. 1a,2b,3c,4d,5e | D. 1a,2d,3e,4c,5b |

16. Дараах гурван зургийг ашиглавал ямар мультимедиа элемент үүсэх вэ?




- A. хөдөлгөөнт зураг
- B. зураг
- C. аудио
- D. бичвэр

17. ICT.wmv файл үүсгэх технологи аль нь вэ?

- A. Moviemaker
- B. Pencil2D
- C. Paint.NET
- D. Audacity

18. Сурагч мультимедиа бүтээлдээ өөрийн дуу хоолойгоор тайлбар оруулжээ. Тайлбараа Audacity программд оруулан засварлах гэсэн боловч дараах алдааны мэдэгдэл гарч иржээ. Дууг хэрхэн засварлаж программд оруулахыг сонгоно уу.



- A. Дууны нэрийг өөрчилж бичнэ.
- B. Дууны өргөтгөлийг өөрчилж бичнэ.
- C. Файл шахах программаар дууны хэмжээг багасгана.
- D. Хөрвүүлэгч программаар дууны төрлийг өөрчилнэ.

19. Сурагч А видео мэдээлэл боловсруулах гар утасны аппликейшин болон программуудыг харьцуулан үзэж нийтлэг байдаг команд, функцүүдийн жагсаалтыг гаргажээ. Тэдгээрийг үүрэг, зориулалттай нь зөв харгалзуулна уу.

- | | |
|-----------|--|
| 1. Effect | a. Өөрийн дуу хоолойг бичих |
| 2. Export | b. Объектыг хувааж тусдаа объектууд болгох |
| 3. Record | c. Видео бүтээл болгон гаргах |
| 4. Split | d. Сонгосон кадрт эфект оруулах |
- A. 1b,2c,3a,4d B. 1d,2a,3c,4b C. 1d,2c,3a,4b D. 1a,2b,3c,4d

20. Өгөгдлийн сангийн тэмдэглэсэн хэсгийг юу гэж нэрлэх вэ?

	Suragch	dugaar	neg	TursunOgnos	Huis	UtasniiDugaar	E-mail
5	Баттар	5	Баттар	1/3/2005	Эрэгтэй	8855 6612	bbaatar@yahoo.com
12	Мөнхномин	12	Мөнхномин	6/28/2004	Эмэгтэй	9545 1234	m.nomio@yahoo.com
4	Намуун	4	Намуун	11/23/2004	Эмэгтэй	9988 9998	tsn@gmail.com
10	Номинчимэг	10	Номинчимэг	8/15/2007	Эмэгтэй	8666 1234	zulb@yahoo.com
11	Номинчимэг	11	Номинчимэг	5/6/2003	Эмэгтэй	9815 5151	nomio@gmail.com
3	Оргил	3	Оргил	10/9/2003	Эрэгтэй	9888 7788	orio@gmail.com
9	Саран	9	Саран	11/18/2006	Эмэгтэй	9551 4562	asar@gmail.com
8	Төглөндербат	8	Төглөндербат	6/26/2005	Эрэгтэй	8987 4561	tbat@yahoo.com
2	Төрболд	2	Төрболд	8/24/2002	Эрэгтэй	9689 8989	tur111@gmail.com
6	Цаглан	6	Цаглан	3/8/2006	Эмэгтэй	9119 1234	tsagaant@yahoo.com
1	Цэлмэг	1	Цэлмэг	9/9/2003	Эмэгтэй	8813 1322	tsee@gmail.com
7	Эрдэнэ	7	Эрдэнэ	9/23/2003	Эрэгтэй	9666 2252	merdenee@yahoo.com

- A. бичлэг
- B. талбар
- C. хүснэгт
- D. эрэмбэлэгдсэн талбар

21. Өгөгдлийн сангийн асуулгын давуу талыг сонгоно уу.


- A. Хүснэгтийн өгөгдлөтэй ажиллахад хялбар, ойлгомжтойгоор харуулах
- B. Хүснэгтийн өгөгдлийг ойлгомжтой, нэгтгэсэн хэлбэрээр цаасан дээр хэвлэх
- C. Өгөгдлийн сангаас тодорхой нөхцөл хангасан бичлэгийг гарган авах
- D. Өгөгдлийн сангийн тодорхой үйл ажиллагааг автоматжуулах хялбар программ

22. Өгөгдлийн санд баганыг _____, мөрийг _____ гэж нэрлэдэг.

№	Код	Бүтээгдэхүүний нэр	Тайлбар
1	2010	Сүү, сүүн бүтээгдэхүүн	ааруул, өрөм, бяслаг
2	2011	Гурил, гурилан бүтээгдэхүүн	талх, боорцог
3	2012	Ус, ундаа	хийжүүлсэн ундаа, ус

- A. үндсэн түлхүүр (primary key), хоёр дахь түлхүүр (second key)
- B. хүснэгт (table), өгөгдөл (data)
- C. багана (column), мөр (row)
- D. талбар (field), бүртгэл (record)

23. Сурагч уншсан номын жагсаалтаа хоорондоо логик холбоотой хүснэгтүүдэд хадгалан хэрэгцээт боловсруулалтыг хийж байхын тулд өгөгдлийн сан үүсгэхээр шийджээ.
Зурагт өгөгдсөн MS Access программын Create цэсээс хүснэгт үүсгэх хэсгийг сонгоно уу.



24. FieldSize тохиргоо ямар үүрэгтэй вэ?
- талбарт авах өгөгдлийн хэмжээ
 - мэдээлэл оруулах хэлбэр
 - дугаарлах
 - тухайн талбарт заавал утга оруулах эсэх
25. Сурагч уншсан номын жагсаалтаа хоорондоо логик холбоотой хүснэгтүүдэд хадгалан хэрэгцээт боловсруулалтыг хийж байхын тулд өгөгдлийн сан үүсгэхээр шийджээ.

UnshijEhelsenOgnoo талбарын шинж чанарыг авах утгатай нь харгалзуулна уу.


- | | |
|--------------------|-------------------------------|
| 1. Caption | a. Short Date |
| 2. Field Size | b. < Date() |
| 3. Required | c. Yes |
| 4. Validation Rule | d. Үншиж эхэлсэн огноо |
| 5. Validation Text | e. Өнгөрсөн огноо оруулна уу! |
- A. 1d,2b,3b,4c,5e B. 1d,2a,3c,4b,5e C. 1e,2a,3c,4b,5d D. 1e,2b,3b,4c,5d

САНАМЖ

- 2.1 хэсгийг [a] даалгаврын зөв хариулт 2 гэж үзвэл [a] мөрний 2 гэсэн нүдийг будна.
- 2.2 хэсгийн даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултыг сонгоно. Жишээлбэл: [a] даалгаврын 4 дэх нь зөв хариу гэж үзвэл [a] мөрний 4 гэсэн нүдийг харандаагаар будна.

ХОЁРДУГААР ХЭСЭГ : ЗАДГАЙ ДААЛГАВАР

- 2.1 Нэгэн сургууль хэвлэмэл номыг цахим болгон бүртгэж авах номын сангийн бүртгэлийн өгөгдлийн сан үүсгэх шаардлагатай болов. Номын сангийн бүртгэлийн нэг хэсгийг жишээгээр харуулав. Дараах асуултад хариулна уу.



- Дээрх өгөгдлийн сан хэдэн хүснэгтээс тогтох байна вэ?
- Дээрх өгөгдлийн сан хэдэн түлхүүр үтгэй вэ?
- Дээрх өгөгдлийн сан хэдэн талбартай (field) байна вэ?
- Хэдэн талбар short text төрөлтэй вэ?
- Хэдэн талбар number буюу тоон төрөлтэй вэ?

2.2 Сурагч уншсан номын жагсаалтаяа хоорондоо логик холбоотой хүснэгтүүдэд хадгалж, хэрэгцээт боловсруулалтыг хийж байхын тулд өгөгдлийн сан үүсгэхээр шийджээ.

Өгөгдлийн санд тохиромжтой интерфэйс буюу маягтыг сонгон ажиллах дараах дасгалуудыг гүйцэтгээрэй.

Дугаар	Номын нэр	Зохиогчийн нэр	Хуудасны тоо	Уншиж эхэлсэн огноо	Уншиж дууссан огноо
1	Миний бие	Ж.Шүрэнцэцэг	60	3/1/2021	3/20/2021
2	Нисдэг алим	З.Түмэнжаргал	133	4/10/2021	5/18/2021
3	Бэмби ба ойн амьдрал	Ф.Залтен	293	5/28/2021	7/10/2021
4	Хандлагын хүч	Жон Максвел	148	7/20/2021	8/18/2021
5	Өөрийгөө хурцлахуй	Жон Todd	168	8/26/2021	10/10/2021
6	Нүүц	Ронда Берн	198	11/11/2021	12/25/2021
7	Би "БИ"-ээрээ амьдралаар	Ким Сү Хёнь	285	1/2/2022	3/2/2022
8	Зүрхийг тань дайлъя	Х.Баасансүрэн	223	3/10/2022	3/30/2022
9	Цойлогсод	Д.Бужинлхам	187	4/10/2022	5/1/2022
*	(New)		0		

Record: **d** of **e** ▶▶▶ No Filter Search

Өгөгдлийн сангийн маягт

a. Өгөгдлийн сангийн маягтад Date/Time өгөгдлийн төрөлтэй хэдэн талбар байна вэ?

- | | | | |
|------|------|------|------|
| 1. 1 | 2. 2 | 3. 3 | 4. 4 |
| 5. 5 | 6. 6 | 7. 7 | 8. 8 |

b. Өгөгдлийн сангийн маягтын доод талд байрлах бичлэгтэй ажиллах хэсгийн - товчны үүргийг сонгоно уу.

- | | | |
|-------------------|-----------------|--------------------|
| 1. Current record | 2. First record | 3. Last record |
| 4. New record | 5. Next record | 6. Previous record |

c. Зурагт өгөгдсөн маягтын хэлбэрийг сонгоно уу.

- | | | | |
|----------------|----------------|----------------|-------------------|
| 1. Blank Form | 2. Datasheet | 3. Design View | 4. Form |
| 5. Form Design | 6. Form Wizard | 7. Layout View | 8. Multiple Items |

d. Өгөгдлийн сангийн маягтыг ажиглаад, доод хэсэгт байгаа d тоо хэд байхыг сонгоно уу.

- | | | | | |
|------|------|------|------|------|
| 1. 1 | 2. 2 | 3. 3 | 4. 4 | 5. 5 |
| 6. 6 | 7. 7 | 8. 8 | 9. 9 | |

e. Өгөгдлийн сангийн маягтыг ажиглаад, доод хэсэгт байгаа e тоо хэд байхыг сонгоно уу.

- | | | | | |
|------|------|------|------|------|
| 1. 1 | 2. 2 | 3. 3 | 4. 4 | 5. 5 |
| 6. 6 | 7. 7 | 8. 8 | 9. 9 | |